



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар

A/189

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 2020 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааны “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 2021 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдааны “аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагатай махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, урамшуулал олгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Л.Батсайхан

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн
дарга:

М.Урандолгио

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтсийн
мэргэжилтэн

Гишүүн:

Х.Нандин-Эрдэнэ


Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний
үйлдвэрлэл, технологи, нийтийн
хоолны асуудал хариуцсан
мэргэжилтэн

2. Аж ахуйн нэгж сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дугаар сарын 18-ны өдрийн
А/215 захирамжийн хавсралт

“Аймгийн баруун бүсийн шилдэг хүлэг” уралдаан

№	Бүсийн уралдаан зохион байгуулах сум	Огноо	Бүсийн нэр
1	Бор-Өндөр	2022.05.13	Аймгийн баруун бүсийн шилдэг хүлэг